

2022 он 03 сар 18 өдөр

Дугаар 22/04

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
зарлан хуралдуулах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.4, 65 дугаар зүйлийн 65.1, 65.3, 65.4, 67 дугаар зүйлийн 67.1, 71 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 3 сарын 18-ны өдрийн эчнээ санал хураалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2022 оны 4-р сарын 30-ны өдрийн 16:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 15-р хороо, Махатма Ганди гудамж-39, Корпорэйт Зочид Буудал Конвеншн Центрийн хурлын танхимд зарлан хуралдуулсугай.
2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, Саналын хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
3. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 4 сарын 8-ны өдрөөр тогтоосугай.
4. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, хоёроос доошгүй өдөр тутмын сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2022 оны 3 сарын 23-ны өдрийн дотор нийтэд зарласугай. Давтан зарыг 2022 оны 4 сарын 6-ны өдөр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, танилцуулга зэрэг бусад холбоотой баримт бичгийг бэлэн болгож 2022 оны 3 сарын 26-ны өдрийн дотор үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.
6. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2022 оны 4 сарын 29-ний өдрийн 14:00 цагаар тасалбар болгосугай.
7. Хурлын даргаар Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ-ийн дарга П.Батбаярыг томилсугай.

2022 он 03 сар 18 өдөр

Дугаар 22/04

Улаанбаатар хот

8. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Хурал зохион байгуулах комиссын дарга:

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ-ийн дарга П.Батбаяр

Хурал байгуулах комиссын гишүүд:

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг

Маркетинг, Борлуулалт эрхэлсэн захирал Ц.Бархас

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Шагж

Олон нийтийн харилцаа эрхэлсэн захирал Ж.Алтангүний

Хянан нийцүүлэлт эрхэлсэн захирал С.Анар-Эрдэнэ

Хөрөнгө оруулалт эрхэлсэн захирал Э.Амарбаясгалан

Санхүү эрхэлсэн захирал Б.Золбоо

9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Тооллогын комиссын дарга:

Г.Алтансүх (Блүмсбюри Секьюритис ҮЦК ХХК)

Тооллогын комиссын гишүүд:

Р.Тогтохбаатар (Блүмсбюри Секьюритис ҮЦК ХХК)

Б.Ариунзул (Блүмсбюри Секьюритис ҮЦК ХХК)

10. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулж, хурлын зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолыг бүрэн дүүрэн, түргэн шуурхай гүйцэтгэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.


11. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн шийдвэр болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэл захирал Ч.Ганхуяг даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

П. Батбаяр

П.БАТБАЯР




/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2022 оны 3 сарын 18-ны өдрийн
22/04 тоот тогтоолын 1-р хавсралт/

**2022 ОНЫ 4 САРЫН 30-НЫ ӨДӨР ХУРАЛДАХ
АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ**

1. Компанийн 2021 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай;
2. Компанийн 2021 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн (цаашид "ТУЗ" гэх)-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2022 оны 3 сарын 18-ны өдрийн
22/04 тоот тогтоолын 2-р хавсралт/

**АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС
(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №1)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2022 оны 4-р сарын 30-ны өдрийн 16:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 15-р хороо, Махатма Ганди гудамж-39, Корпорэйт Зочид Буудал Конвеншн Центрийн хурлын танхимд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	Хурлаас гарах шийдвэрийн томъёолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.			

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол зуучлагч Үнэт цаасны компани (ҮЦК) дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэх нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.
4. Завсарласан болон балласан, залруулгатай санал авах хуудсыг хүчингүйд тооцно.
5. Саналыг саналын хуудсаар эсвэл цахимаар өгөх боломжтой.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____

Санал авах хуудсыг үйлдсэн 2022 оны ... -р сарын ... өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын дарга _____/...../

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2022 оны 3 сарын 18-ны өдрийн
22/04 тоот тогтоолын 3-р хавсралт/

**"АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 3 сарын 18-ны өдрийн 22/04 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах тухай зарлаж байна.

Компанийн оноосон нэр: Ард Санхүүгийн Нэгдэл ХК (AARD)

Хурал хуралдуулах газар: Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 15-р хороо, Махатма Ганди гудамж-39, Корпорэйт Зочид Буудал Конвеншн Центрийн хурлын танхим

Огноо: 2022 оны 4 сарын 30-ны өдрийн 16:00 цагт

Санал өгөх хэлбэр: Ард Апп (Ard App) болон цаасаар саналаа өгнө.

2022 оны 4 сарын 30-ны өдөр хуралд оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчид урьдчилсан санал өгөх боломжтой. Саналыг Ард Секюритиз ҮЦК ХХК компанийн Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1304 тоот хаягаар дамжуулан авах ба саналын хуудас хүлээн авах сүүлийн хугацааг 2022 оны 4 сарын 29-ний өдрийн 14:00 цагаар тасалбар болгоно.

Хурлын хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2021 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай;
2. Компанийн 2021 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн (цаашид "ТУЗ" гэх)-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;

Бүртгэлийн өдөр: 2022 оны 4 сарын 8-ний өдөр

Хуралд бэлтгэх явцад Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлан;
2. Компанийн 2021 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт
3. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудасны загвар;
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл.

Хувьцаа эзэмшигч та 2022 оны 3 сарын 31-ний өдрөөс хойш ажлын өдрүүдэд ажлын цагаар өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид хандах, эсхүл www.ardholdings.com цахим хуудсаар зочлон хурлын материалтай танилцах боломжтой.

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 17 давхар
Утас: 77078080

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

*/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2022 оны 3 сарын 18-ны өдрийн
22/04 тоот тогтоолын 4-р хавсралт/*

**АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИГ
ХУРЛААР
ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ МАТЕРИАЛ**

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлан;
2. Компанийн 2021 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт
3. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудасны загвар;
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл.

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн
377 дугаар тогтоолоор баталсан "Хувьцаат компанийн хувьцаа
эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын 1-р Хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр	Ард Санхүүгийн Нэгдэл ХК
Хаяг	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 17 давхар
Хурал хуралдах өдөр, цаг	2022 оны 4 сарын 30-ны өдөр, 16:00 цаг
Хурал хуралдах газар /хаяг, байршил/	Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 15-р хороо, Махатма Ганди гудамж-39, Корпорэйт Зочид Буудал Конвеншн Центрийн хурлын танхим
Хурлын төрөл	Ээлжит
Хурал зарлагч	Төлөөлөн Удирдах Зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо	2022 оны 3 сарын 18-ний өдөр
Олон нийтэд зарлах огноо	2022 оны 3 сарын 22-ний өдөр
Бүртгэлийн өдөр	2022 оны 4 сарын 8-ны өдөр
Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо	2022 оны 3 сарын 26-ны өдөр
Хүргүүлсэн огноо	2022 оны 3 сарын 21-ний өдөр
Хурлын даргын нэр	Пүрэвжаргал овогтой Батбаяр
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэрс	Тооллогын комиссын дарга: Г.Алтансүх Тооллогын комиссын гишүүн: Б.Ариунзул, Р.Тогтохбаатар
Баримт, бичгийн жагсаалт	Хавсралтаар
Баримт, бичгийн хуудасны тоо	9

Хурал зохион байгуулах комиссын дарга

П.Батбаяр - 2

2022 оны 3 сарын 21-ний өдөр